

Ч.Өлзийсайхан

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

Монголын улс төрийн элит давхарга дахь жендерийн асуудалд

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд Улс төрийн элит давхаргыг судалсан байдал, улс төрийн салбарын үүднээс судлахдаа анхаарах зүйлүүдийг юуны өмнө гаргасан. Улс төрийн элит бүтцийн дийлэнхийг бүрдүүлж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адил байгаа шинжүүд, нийгмийн бусад давхаргаас ялгагдах онцлог давуу талууд мөн эрчүүдийн эмэгтэйчүүдээс илүү давуу байх онцлог талууд, бас сул талуудыг гаргахыг эрмэлзсэн болно. Улс төрийн элит эмэгтэйчүүдэд байгаа дээр шинжүүдийг тодорхой харуулахыг оролдсон бөгөөд сул талыг давж гарахад юу анхаарах ёстой талаар тодорхой саналуудыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Улс төрийн хошуучлал, элит, лидер, жендер

Улс төрийн засаглалын мөн чанараас урган гарч ирдэг нэг чухал асуудал бол нийгэм дэх удирдагч, удирдуулагчийн асуудал, засаглалын объект субъектийн асуудал байдаг. Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн элит гэж тодорхойлогддог нийгмийн дээд давхаргын асуудлыг өмнөх үеийнхээс огт өөрөөр тавих ёстой гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрөх болсон. Гэвч энэ талаархи өнгөрсөн үзэл баримтлалыг үгүйсгэсэн боловч шинээр гаргаж тавьсан зүйл, ялангуяа өөрийн орны элит давхаргыг нарийвчлан судласан зүйл нэн ховор байна. Монголын улс төрийн элит давхаргыг судлахын тулд харгалзан үзэх ёстой, уялдаа холбоонд нь авч үзэх ёстой хэд хэдэн чухал асуудал байна. Үүнд:

- улс төрийн элитийн засаглалын мөн чанар, онцлог
- улс төрийн элитүүдийн үйл ажиллагаагаа явуулах байдал нь улс төрийн системээсээ хамаарсан байдал
- тэдний төрийн удирдлагаа хэрэгжүүлэх арга, механизм
- улс төрийн элитүүдийн төлөвшилт, бүтцэд намын систем, сонгуулийн системийн нөлөөлөх байдал
- ард түмний улс төрийн соёл, уламжлал
- улс төрийн процесс, зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замууд
- олон улсын нөхцөл байдал

Улс төрийн элитийн асуудлыг нарийвчлан авч үзэх гэвэл гарцаагүй харгалзаж үзэх ёстой эдгээр нөхцөлүүдээс гадна зарим нэг дагалдах онцлог байдлууд байж болохыг үгүйсгэхгүй байна.

Дараагийн нэг чухал зүйл нь улс төрийн элит гэдэгт чухам хэнийг оруулж үзэх юм бэ гэсэн асуудал байна. Энэ асуудлыг элитийн сонгодог төлөөлөгчид ч өөрсдийн зохиол бүтээлдээ яг таг зааглах боломжгүй гэж үзсэн байдаг бөгөөд энэ нь нийгмийн харилцаа улам нарийн бүтэцтэй болсон үед бүр ч их бэрхшээлтэй болсон ажээ. Янз бүрийн санаа бодол байна. Төр засгийн удирдах хүмүүсийг, намын аппаратын удирдлагынхныг, намын идэвхитэй гишүүдийг, сэхээтнүүдийг, нийгмийн баян чинээлэг хэсгийнхнийг гэх мэтээр олон янзаар авч үзсэн нь бий. Тэгэхээр улс төрийн элит гэсэн давхаргад хамруулж үзэхийн тулд дараахь шинжүүдийг юун түрүүнд харгалзан үзэх ёстой.

- Тэдэнд төрийн засаглал яг гарт нь байна уу, үгүй ядахдаа шийдвэрлэх нөлөө үзүүлэх чадвар байна уу?
- өөрсдийн хүсэл зоригыг нийгэмд тулган хүлээлгэж чадаж байна уу

- дээрхи хүн, бүлэглэл нь өөрсдийн шийдвэрээ тулган хүлээлгэхэд нь нөлөөлөх ямар хүчин зүйлүүд байна вэ
- тэд улс төрийн засаглалаас хэрхэн холдож байна. Түүний шалтгаан нь юу байна.
- Тэр бүлэглэл, хүн улс төрийн элит болон гарч ирэхэд зөвхөн манай оронд л байж болох өвөрмөц онцлог юу байж болох вэ.

Эдгээр асуудлыг цогцоор нь авч үзэж байж монголын улс төрийн элитийн ямар нэг төсөөлөлтэй боллоо гэж үзэж болох юм. Гэвч энэ бүх зүйлийг бүгдийг нь бүрэн цэгцтэйгээр авч үзэж мөн чанарыг нь харуулах гэдэг нь өөрөө асар их ажил байгаа бөгөөд энэ талын судалгаанд манай улс төр судлаачид, социологчид өөрсдийн анхаарал, хүч бололцоо, мэдлэг чадвараа дайчлан оролцох ёстой чухал сэдэвийн нэг яах аргагүй мөн билээ.

Аль ч улс оронд нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудалтай холбоотой шийдвэрүүдийг улс төрийн удирдлага л гаргаж байдаг. Тодруулж хэлбэл улс төрийн удирдлага бол хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд хамгийн хүчтэй нөлөө үзүүлэгч субъект. Нэгэнт улс орны хөгжлийн асуудлыг ярьж байгаа болохоор эдийн засгийн удирдлагаас ангид орших боломж бараг үгүй. Иймд сүүлийн 2 жил гаруй хугацаанд монголын нийгмийн амьдрал, хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулж байгаа, олон түмэнд илэрхий хүлээн зөвшөөрөгдсөн улс төрчид болон хэдийгээр олон түмэнд үргэлж танигдаж нүдлэгдээд байдаггүй боловч нийгэмд нэгэнт эзэлсэн байр суурь нь улс орны амьдралд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг гэж үзсэн 350 гаруй хүмүүсийн талаар материал цуглуулж энэ давхаргын онцлог, бүтэц, үйл ажиллагаагаа явуулах механизм, хоорондын зөрчил тэмцэл, алдаа оноо, нийгмийн зүгээс өгч байгаа үнэлэмж зэргийг гаргахыг хичээж байгаа билээ.

Монголын улс төрийн элитүүдийг үндсэнд нь бүрдүүлээд байгаа тэр эрчүүд маань ямар онцлог шинжтэй юм бэ, тэдэнд эмэгтэйчүүдээс үнэхээр илүү давуу талууд байна уу, эсвэл ингэж дийлэнхи хувийг эзлэхэд эмэгтэйчүүдийн сул дорой байдал нөлөөлж байна уу гэдгийг гаргаж үзэхийг оролдоё. Энэ дүгнэлтийг хийхдээ зүгээр нэг санаанаасаа тааварлаж үзсэнгүй харин сүүлийн 20 гаруй жил улс төрийн болон нийгэм, эдийн засгийн амьдралд болж өнгөрсөн олон үйл явдлуудыг шүүн тунгааж олон дахин давтагдаж байгаа шинжүүдийг нь харгалзан үзэж жендерийн асуудалтай нь холбон тайлбарлах гэж оролдсоноо дахин хэлье.

Эрчүүд болон эмэгтэйчүүдэд аль алинд нь нийгмийн бусад давхаргатай харьцуулахад илүү байгаа давуу талуудад:

- өндөр боловсрол
- Мэргэжлийн хувьд боловсорсон
- шинэ зүйлээр оюунаа сэлбэх чадвар
- эрмэлзлэл тэмүүлэл ихтэй
- хувь хүнийхээ хувьд алдар гавьяанд хүрсэн, үйл ажиллагааныхаа салбарт амжилтанд хүрсэн байх
- шилмэл байхын тулд өрсөлдөх чадвартай зэрэг шинжүүд орж байна.

Гэтэл улс орны амьдралд жинтэй хувь нэмэр оруулж байгаа эрчүүд маань өөрсөдтэйгээ адил түвшинд байгаа эмэгтэйчүүдтэйгээ харьцуулахад дараахь давуу талуудтай болох нь илт харагдаж байна. Үүнд:

- Эрчүүд нийгэм улс төрийн шинжтэй шинэ үйл явцыг эхлүүлэх зориг чадвараар эмэгтэйчүүдээс илт давуу байна. Тэд нийгэм улс төрийн системийг ч өөрчлөх чадвар, түүнийхээ төлөө халшрахгүй тэмцэх

зориг хатуужилтай. Эмэгтэйчүүдэд ийм чадвар байж мэдэх л юм. Гэхдээ яг одоогоор тэгж чадсан байна гэж хэлэх жишээ нэг их харагдахгүй байна.

- Улс төрийн даацтай том тохиролцоонд хүрэх чадвар илүү
- Юмны гол мөн чанарыг харах чадвар илүү, үүний дотор ард түмний язгуур эрх ашгийг олж харж, илэрхийлэх чадвар илүү харагдаж байна. Өөрөөр хэлбэл улс төрийн хараа сайтай.
- Улс төрийн үйл явцад гарч байгаа өөрчлөлтийг түргэн мэдэрч түүнийг овжиноор ашиглах чадвар эрчүүдэд давуу байна.
- Өөрийнхөө байр суурин дээр тууштай зогсох, өөрийнхөө үзэл бодлыг хэрэгжүүлэхийн төлөө зүтгэх чадвар илүү.
- Өөрсдийн цаг үе нь дууссан бол ойлгож, хүлээцтэй хандах чадвар сайн
- Өмчийн хуваарилалт, эдийн засгийн чухал ач холбогдолтой салбаруудыг хяналтандаа авах чадвар эмэгтэйчүүдтэй зүйрлэшгүй их
- Улс төрийн өрсөлдөөн, үйл явц дунд хүнд цохилт амссан ч эргээд гараад ирэх сэтгэлийн хат тэнхээ гарцаагүй илүү. Эмэгтэйчүүд тийм их хохирол амсахаар өндөр байр сууринд ч очиж чадахгүй байна.

Улс төрийн элит бүтцийн дийлэнхи хувийг бүрдүүлж байгаа эрчүүдэд үүнээс их сайн чанарууд байгаа гэдэг нь эргэлзээгүй. Гэвч эрчүүдэд улс орны амин чухал асуудлыг шийддэг хүмүүсийн хувьд илүүц, сул талууд бас байна. Үүнд:

- Тэд эрх мэдэлд дэндүү их тэмүүлж байна. Өөрсдөө тэр ажилд тохирох, тохирохгүй, хийж чадах, чадахгүйг үл харгалзан зүтгэх талаараа эмэгтэйчүүдээс илүү. Энэ нь хуучин социализмын үед ч, шинэ цагийн ардчиллын үед ч адилхан харагдаж байна. Энэ байдал 1996-2000 онд Ардчилсан холбоо эвсэл засгийн эрх барьсан 4 жилийн хугацаанд илүү тодорхой харагдсан. Хүчний харьцаа МАХН-д ашигтай байгаа одоогийн парламентын үед хийгдэж байгаа томилгоонууд, томилолтын төлөө өрсөлдөөн ч үүнийг лавтай батлах билээ. Ялангуяа гүйцэтгэх засаглал дээр 1980-аад оноос өмнө мэргэжил мэдлэгийнх нь дагуу томилгоо хийгдэж байсан бол одоо энэ байдал үгүй болсон гэж хэлж болно. Засгийн газрын гишүүд, сайд нарыг бодлого гаргах, шийдвэрлэх чадварыг нь голлож харж байгаа гэсэн үгээр халхавчилдаг боловч энэ чадвар нь эзэмшсэн мэргэжилтэй нь дөхүү бол илүү сайн баймаар. Гэтэл манайд болохоор зориуд тэгсэн юм шиг бараг бүгдийг нь зөрүүлээд тавьчихсан байдаг нь сонин. Тэгэхээр ажил явуулах гэдгийг нь эрх мэдэл хуваарилахад хувь хүртэхээс дээгүүр тавьчихсан ч юм шиг дүр төрх харагддаг.
- Хэдийгээр ард түмний язгуур эрх ашгийг олж харах, илэрхийлэхдээ эмэгтэйчүүдээс давуутай ч нэгэнт эрх мэдэлд хүрсэн бол үйл ажиллагаандаа олон түмний санаа бодлыг тусган ажиллах чадвар муутай. Тэдний өдөр тутмын амьдралыг нь ойлгох, мэдрэх мэдрэмж бага.
- Бие биенийгээ шийтгэх, өс хонзон авахдаа их хатуу. Энэ нь социализмын үед ч, ардчиллын үед ч адилхан байж л байна.
- Эрчүүд нийгэмд асар их нэр хүндтэй чухал байр сууринд очсон мөртлөө түүндээ тохируулж биеэ авч явах талаар эмэгтэйчүүдээс муу. Архи уух, хүн зодох танхайрах гэх мэтээр үлгэргүй байдлаар биеэ авч явчихаад огт юм болоогүй мэт дараа нь өөр чухал албан тушаалын төлөө өрсөлдөөд явж байж чадах улайхгүй нүүр эрчүүдэд л байдаг бололтой.
- Удирдлага, зохион байгуулалтын бүтцэд өндөр байр суурь эзэлсэн л бол өөрсдийн бүлэглэлээс гадуур үлдсэн шинэ хүмүүсээр шинэчлэгдэх, хүч сэлбэх, олон түмнийг мэдрэх тал дээр эмэгтэйчүүдээс муу.

сажиг зүйлийг эс тооцвол эдийн засгийн томоохон гэмт хэргүүдэд улс төрч эмэгтэйчүүдийн нэр байхгүй байна.

- Өөрт оногдсон үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах чадвар эмэгтэйчүүдэд илүү байна. Жишээлбэл ардчилсан холбоо эвслийн үед их хурлын нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдааныг тасласнаараа дээд рекорд тогтоож хэвлэл мэдээллээр зарлагдсан хүмүүсийн дотор эмэгтэйчүүдийн нэрс байхгүй.

Эмэгтэйчүүдэд дээрхи сайн талууд байдаг ч гэсэн тэднийг хоёрдугаар зэрэгт тавиулаад байдаг хүчин зүйл, сул талууд бас байна. Энд юуны өмнө угаасаа улс төр бол эр хүний ажил, эмэгтэй хүн түүнд зөвхөн туслагчийн үүргийг гүйцэтгэх ёстой гэж үздэг нийгэмд бүхэлд нь тогтсон сэтгэлгээ. Тиймээс ч хичнээн олон эмэгтэй улс төрчид сонгуульд өрсөлдөө ч, эрх мэдэл бүхий байр суурийн төлөө явлаа ч нийгэм бүхэлдээ болон, дээд давхаргынхан ч гэсэн тэдэнд бололцоо олгохгүй байна.

Эмэгтэйчүүд нийгэм улс төрийн чухал асуудлыг эхлүүлэх зориг, чадвар муу гэсэн дүгнэлт хийхээс аргагүй.

Эмэгтэй улс төрчдийн ерөөсөө өөрсдөө авч үзэж анхаарч байгаа, оролцож байгаа асуудал нь ихэвчлэн нийгмийн л асуудал байдаг. Тэрнээс биш улс төрийн эгзэгтэй байдал бий болоход эрчүүдийн зэрэгт хүрч үнэлэлт дүгнэлт өгч байгаа эмэгтэйчүүд алга байна. Дуугарлаа гэхэд нөгөө л эрчүүдийн аль нэг бүлэглэл, эрх мэдэлтнийг хамгаалж ярихаас биш биеэ даасан шийдвэртэй алхам хийж байгаа юм байхгүй.

Нийгэмд тогтсон сэтгэлгээ нь ч гэсэн тэдний санаа бодол яахав тусгагдаж байг, бидэнд ойр асуудлыг шийдэхэд хэрэг болох байх гэсэн сэдэлтэй байхаас биш улс оронд хэрэгтэй даацтай бодлого явуулна гэж нэг их төсөөлдөггүй.

Эмэгтэйчүүд намын харьяаллаас болоод нөгөө нийгмийн асуудлаа шийдэх болохоор дуугарч өгөхгүй тохиолдлууд гарч байдаг. Өөрөөр хэлбэл өөрсдөө хамгийн их нэгдэлтэй дуугарч байх асуудал дээрч эв нэгдэл муутай тал харагддаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн элит хэсэгт багтаж орж ирж байгаа арга зам нь ч эмэгтэйчүүд, хүүхдийн асуудал, ядуурал гэх мэт дээр л олон жил ажиллаж энэ чиглэлээр олонд танигдаж хатуухан хэлбэл за яахав эднийг оруулья даа яахав гэсэн эрчүүдийн өгөөмөр сэтгэлийн буянаар юм шиг гарч ирдэг. Түүнээс биш эрчүүд шиг тэмцэлдэж, улс төрийн бодлого дээр ухаанаа уралдуулж олонд танигдсан нь цөөхөн. Энэ мэт шалтгаанууд улс төрийн элит бүтцэд эрэгтэйчүүд дийлэнхи хувийг эзлэхэд хүргэж байна. Тоо баримтаар жишээ авч үзвэл, 1990 оны АИХ-ын сонгуульд өрсөлдсөн нийт хүмүүсийн 25% орчим нь эмэгтэй байсан бол сонгуулийн дүнгээр 422 гишүүнээс дөнгөж 9 эмэгтэй сонгогдож чаджээ. Энэ нь нийт гишүүдийн 2,1% гэсэн үг. Энэ баримт бол нэг талаас олон түмэн хүнд бэрх цаг, ороо бусгаа үед эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдэд итгэл найдвар хүлээлгэдэгийг, нөгөө талаас сонгуульд өрсөлдөх хүмүүсийг гаргаж ирэхдээ квот тогтооно гэдэг нь яг ийм харьцаагаар парламент, засгийн газар гэх мэт чухал субъектуудад эмэгтэйчүүд байр эзэлж чадна гэсэн үг огт биш гэдгийг харуулж байна. Тэгэхээр эмэгтэйчүүд олон түмний итгэл найдварыг хүлээхийн тулд харах зүйлийнхээ хүрээг өргөжүүлэхээс өөр аргагүй. Өмнөх болон одоогийн парламентад 8 эмэгтэй сонгогдсон нь нийт гишүүдийн дөнгөж 10,5 % нь л болж байна. Өмнөх нийгмийн үед МАХН-ын УТТ, яамдын сайдууд дотор эмэгтэйчүүд байдаггүй байсан тэр жаяг өнөө үед нэг их өөрчлөгдсөнгүй.

Хэлмэгдсэн, хорлогдсон гэх мэт хэцүү зүйлүүд тэднийг л дайрч гардаг нь аль ч нийгмийн үед байсан зүйл.

Тэгвэл эрх баригч элитүүдэд орж чадсан эмэгтэйчүүд ямар онцлогтой хүмүүс вэ гэдгийг бас тодорхойлохыг оролдъё. Дээр дурдсанчлан тэдэнд өндөр боловсрол, мэргэжлийн хувьд боловсорсон байдал, шинэ зүйлээр оюунаа сэлбэх чадвар, эрмэлзлэл тэмүүлэлтэй байх, хувь хүнийхээ хувьд алдар гавьяанд хүрсэн, үйл ажиллагааныхаа салбарт амжилтанд хүрсэн байх, шилмэл байхын тулд өрсөлдөх чадвартай зэрэг шинжүүд гарцаагүй байна. Тэгэхээр Голландын философич Бенедикт Спиноза (1632-1677) жам ёсны эрхийн онолыг баримтлан үзэл баримтлалаа боловсруулах явцдаа төрийн удирдлагад оролцуулж болохгүй хүмүүст

-гадаадын иргэд

-эмэгтэйчүүд

-хүүхэд болон насанд хүрээгүй хүмүүс

-гэмт хэрэгтнүүдийг хамааруулна гэж үзсэн байдаг нь тэр үеийнхээ эмэгтэйчүүдэд л тохирч байсан байж магадгүй, харин орчин үеийн эмэгтэйчүүдэд огтхон ч тохирохгүй дүгнэлт юм байна.

Эмэгтэйчүүдэд эрчүүдээс илүү сайн талууд ажиглагдаж байна. Үүнд:

- Хэцүү бэрх цаг тулгарахад санаа нэмэрлэх, маш оновчтой зөвөлгөө өгөх чадвар эмэгтэйчүүдэд их байна. Магадгүй тэд өөрсдөө л өөрсдийгөө хоёрдугаарт тавиад голлох шийдвэрийг гаргадаггүй болохоос биш эрчүүдээс нэг их дутаад байхгүй улс төрийн холч хараа байж магадгүй. Энэ нь Монголын нууц товчооноос авахуулаад л 1990 ээд оны үеийн бужигнаан дунд ч л харагдаж байна.
- Хүнд хэцүү цаг үе тулгарч гэмээ нь өөрийгөө л аваад гарья гэх санаа харьцангуй бага юм шиг харагдах юм. Би та нарт түрүүн нь ингэж хэлээд л байсан, та нар миний үгэнд ороогүйгээс ийм буруу зүйл хийгдчихлээ, тэгэхээр би л буруугүй шүү гэж хэлдэг үг эмэгтэйчүүдийн амнаас нэг их гардаггүй юм байна.
- Эрчүүд улс төрийн шийдвэр гаргах түвшинд гарч ирэхээрээ улс орныг хүчирхэг болгох гэдэг зүйлийг л голлож яриад харин тэр хүчирхэг болтлоо ард түмэн эрүүл саруул байна уу, хоол ундтай байна уу, үр хүүхэд нь сурч боловсрох нөхцөл байдал ямар байна гэх мэт нийгмийн асуудлыг анхаарахдаа муу, энэ тал дээр гарч байгаа бэрхшээлтэй зүйлийг олж харах тал дээр байгалийн инстинкт нь эмэгтэйчүүдийг эрчүүдээс гарцаагүй дээгүүр тавихад хүргэж байна. Тэгэхээр эрчүүд зорилго нь зөв байх ёстой, гэхдээ түүнд хүрэх арга зам нь ч гэсэн хүнлэг байх ёстой гэсэн зарчмыг мартажгүй санаж явах хэрэгтэй юм болов уу. Зарим оронд ногоон намд байгаль орчны яамыг удирдах бололцоог үргэлж олгодог туршлага байдаг. Тэгэхээр нийгмийн асуудал хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа манай орны хувьд нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамыг ер нь эмэгтэйчүүд удирдаж байвал илүү зохистой байж ч болох л юм. Юутай ч Эрүүл мэндийн яамыг эмэгтэй хүн тэргүүлж байгаа явдал бол маш зөв зүйтэй зүйл мөн гэж хэлэх байна. Нийгмийн асуудлаар эмэгтэйчүүдийн баримтладаг тэр тогтвортой үзэл баримтлалыг эрчүүд сонгууль, улс төрийн ээдрээтэй нөхцөл байдлын үед л их ярьж, ашигладаг гэж үзэж байна.
- Эмэгтэйчүүд эрчүүдтэй харьцуулахад илүү шударга хүмүүс бололтой. Дээр дурдсанчлан Сонгуулийн үед өгсөн гурил будаа гэх мэтийн жижиг

сажиг зүйлийг эс тооцвол эдийн засгийн томоохон гэмт хэргүүдэд улс төрч эмэгтэйчүүдийн нэр байхгүй байна.

- Өөрт оногдсон үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах чадвар эмэгтэйчүүдэд илүү байна. Жишээлбэл ардчилсан холбоо эвслийн үед их хурлын нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдааныг тасласнаараа дээд рекорд тогтоож хэвлэл мэдээллээр зарлагдсан хүмүүсийн дотор эмэгтэйчүүдийн нэрс байхгүй.

Эмэгтэйчүүдэд дээрхи сайн талууд байдаг ч гэсэн тэднийг хоёрдугаар зэрэгт тавиулаад байдаг хүчин зүйл, сул талууд бас байна. Энд юуны өмнө угаасаа улс төр бол эр хүний ажил, эмэгтэй хүн түүнд зөвхөн туслагчийн үүргийг гүйцэтгэх ёстой гэж үздэг нийгэмд бүхэлд нь тогтсон сэтгэлгээ. Тиймээс ч хичнээн олон эмэгтэй улс төрчид сонгуульд өрсөлдөө ч, эрх мэдэл бүхий байр суурийн төлөө явлаа ч нийгэм бүхэлдээ болон, дээд давхаргынхан ч гэсэн тэдэнд бололцоо олгохгүй байна.

Эмэгтэйчүүд нийгэм улс төрийн чухал асуудлыг эхлүүлэх зориг, чадвар муу гэсэн дүгнэлт хийхээс аргагүй.

Эмэгтэй улс төрчдийн ерөөсөө өөрсдөө авч үзэж анхаарч байгаа, оролцож байгаа асуудал нь ихэвчлэн нийгмийн л асуудал байдаг. Тэрнээс биш улс төрийн эгзэгтэй байдал бий болоход эрчүүдийн зэрэгт хүрч үнэлэлт дүгнэлт өгч байгаа эмэгтэйчүүд алга байна. Дуугарлаа гэхэд нөгөө л эрчүүдийн аль нэг бүлэглэл, эрх мэдэлтнийг хамгаалж ярихаас биш биеэ даасан шийдвэртэй алхам хийж байгаа юм байхгүй.

Нийгэмд тогтсон сэтгэлгээ нь ч гэсэн тэдний санаа бодол яахав тусгагдаж байг, бидэнд ойр асуудлыг шийдэхэд хэрэг болох байх гэсэн сэдэлтэй байхаас биш улс оронд хэрэгтэй даацтай бодлого явуулна гэж нэг их төсөөлдөггүй.

Эмэгтэйчүүд намын харьяаллаас болоод нөгөө нийгмийн асуудлаа шийдэх болохоор дуугарч өгөхгүй тохиолдлууд гарч байдаг. Өөрөөр хэлбэл өөрсдөө хамгийн их нэгдэлтэй дуугарч байх асуудал дээрч эв нэгдэл муутай тал харагддаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн элит хэсэгт багтаж орж ирж байгаа арга зам нь ч эмэгтэйчүүд, хүүхдийн асуудал, ядуурал гэх мэт дээр л олон жил ажиллаж энэ чиглэлээр олонд танигдаж хатуухан хэлбэл за яахав эднийг оруулья даа яахав гэсэн эрчүүдийн өгөөмөр сэтгэлийн буянаар юм шиг гарч ирдэг. Түүнээс биш эрчүүд шиг тэмцэлдэж, улс төрийн бодлого дээр ухаанаа уралдуулж олонд танигдсан нь цөөхөн. Энэ мэт шалтгаанууд улс төрийн элит бүтцэд эрэгтэйчүүд дийлэнхи хувийг эзлэхэд хүргэж байна. Тоо баримтаар жишээ авч үзвэл, 1990 оны АИХ-ын сонгуульд өрсөлдсөн нийт хүмүүсийн 25% орчим нь эмэгтэй байсан бол сонгуулийн дүнгээр 422 гишүүнээс дөнгөж 9 эмэгтэй сонгогдож чаджээ. Энэ нь нийт гишүүдийн 2,1% гэсэн үг. Энэ баримт бол нэг талаас олон түмэн хүнд бэрх цаг, ороо бусгаа үед эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдэд итгэл найдвар хүлээлгэдэгийг, нөгөө талаас сонгуульд өрсөлдөх хүмүүсийг гаргаж ирэхдээ квот тогтооно гэдэг нь яг ийм харьцаагаар парламент, засгийн газар гэх мэт чухал субъектуудад эмэгтэйчүүд байр эзэлж чадна гэсэн үг огт биш гэдгийг харуулж байна. Тэгэхээр эмэгтэйчүүд олон түмний итгэл найдварыг хүлээхийн тулд харах зүйлийнхээ хүрээг өргөжүүлэхээс өөр аргагүй. Өмнөх болон одоогийн парламентад 8 эмэгтэй сонгогдсон нь нийт гишүүдийн дөнгөж 10,5% нь л болж байна. Өмнөх нийгмийн үед МАХН-ын УТТ, яамдын сайдууд дотор эмэгтэйчүүд байдаггүй байсан тэр жаяг өнөө үед нэг их өөрчлөгдсөнгүй.

Монголын улс төрийн элитийн бүтэц дэх жендерийн харьцааны асуудлаас үүдэн хувийн зүгээс санал болгомоор хэд хэдэн зүйл байна. Үүнд:

- эмэгтэйчүүд улс төрд ухаалаг бодлого явуулах билэг, чадвар бий гэдгийг нийгмийн дунд хэвшүүлэх, мэдээж энэ нь тодорхой цаг хугацаа, хүч чармайлт шаардсан ажиллагаагаар дамжин хэрэгжих болно.
- эрчүүд эмэгтэйчүүдийнхээ давуу талыг хүлээн зөвшөөрч тэдэнд угаасаа очих ёстой орон зайг нь тавьж өгөх хэрэгтэй. Үүнийг өнөөгийн нөхцөл байдалд, нийгэмд тогтсон сэтгэлгээтэй нь уялдуулаад хэдийгээр үр дүн нь эргэлзээтэй ч гэсэн квот тогтоох арга замыг сонгохоос өөр аргагүй.
- Ерөөсөө эрэгтэйчүүд эмэгтэйчүүд тэгш эрхтэй учраас яг адилхан байх ёстой гэдэг бол хүн төрөлхтөнд угаасаа заяагаагүй зүйл юм шиг байна. Эрэгтэйчүүд нийгмийн удирдахад дийлэнхи хувийг эзлэх гэдэг нь юутай ч бидний харж байгаа ирээдүйд гарцаагүй зүйл. Харин нийгмийн дээд статустай байр сууринд 2-10-хан хувийн хооронд хэлбэлзээд байгаа эмэгтэйчүүдийн оролцоог бусад хөгжилтэй орнуудад байгаа 20 орчим хувьд нь хүргэхэд эрэгтэйчүүд маань бас жаахан сэтгэлтэй, эмэгтэйчүүд бас санаачлагатай, зоригтой ажиллах хэрэгтэй байна.
- Хамгийн дээд түвшний буюу нийгэм улс төрийн лидер, тэргүүлэх хүмүүс, дунд түвшний буюу сонгуулиар гарч ирдэг дээд албан тушаалтнууд, засаг захиргааны элитүүд буюу төр захиргааны байгууллагын дээд албан тушаалтнууд гэсэн аль ч ангилалд нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн төлөөлөл зохистой харьцаагаа барьж байх хэрэгтэй байна.
- эмэгтэйчүүд нь ч гэсэн биологи, психологийн талын хүлээснээсээ гарч шийдэх оролцох асуудлынхаа хүрээг илүү өргөн болгох хэрэгтэй санагдаж байна.
- эмэгтэйчүүд ажиллаж байвал илүү зохистой төр засгийн өндөр албан тушаалуудад тэднийг томилуулах талаар эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалдаг олон байгууллагууд оновчтой цагт, оновчтой үгээ хэлдэг баймаар байна.

Эцэст нь хэлэхэд хэрвээ эмэгтэйчүүд эрчүүдийн зэрэгт хүрч өөрсдийн оролцоо, сэтгэлгээнийхээ хүрээг өргөжүүлэхгүй бол нэг их улс төрд оролцох, удирдах гэж зүтгээд байх хэрэггүй ч байж магадгүй. Гэхдээ энэ нь улс төрийн зүтгэлтэн эрэгтэйчүүд өөрсдөө байгаа сул талаа засчихаад өөгүй сайхан хүмүүс болчихсон үед бол боломжтой зүйл байж болох юм.

Ашигласан материал

1. Ё. Баатарбилэг. Монголын түүхийн арван долоон жаран. 1027-2000 он. УБ., 2000 он
2. Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажилт, хөгжил, хандлага. УБ., 2002
3. Г.Алмонд. Харьцуулсан улс төр. УБ., 2005 он
4. Д. Содном. Амьдрал бодол. УБ., 2003
5. Б.Оюун-Эрдэнэ. 2000-2004. 76. Хэн нь хэн бэ?. УБ., 2004 он
6. Лха. А.Юндэндорж. Лха.Ю.Атар. Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн сургаал. II-III, Хөх хот. 2003
7. Д.Энхцэцэг. Women of Mongolia. Past and present. МУИС. НШУС. Эрдэм шинжилгээний бичиг. Түүх. IV